



LEGAL NEWSLETTER

2026.06.30

№65

AKP Law Firm

Бид 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд мөн батлагдсан тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна.

I. ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД:

1.1 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуульд "чухал ашигт малтмал" гэсэн шинэ ангилал нэвтэрч, стратегийн ач холбогдол бүхий ордуудыг ард түмний мэдэлд байлгах зарчмыг бэхжүүлж байна. Мөн "Ашигт малтмалын баяжуулалт" хариуцсан бүхэлдээ шинэ бүлэг нэмэгдэж, баяжуулах үйл ажиллагаа эрхлэхэд Ашиглалтын тусгай зөвшөөрлөөс тусад нь Баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардах болж байна — үүнийг хяналтгүй, далд байдлаар явагдаж буй баяжуулах үйл ажиллагаанаас үүдэх эрсдэлийг арилгах зорилготой гэж үзэл баримтлалд дурджээ. Улсын төсвийн бус хувийн хөрөнгөөр геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх шинэ гэрээт зохицуулалт, түүнчлэн маркшейдерийн тусгай зөвшөөрлийн зохицуулалт мөн нэмэгдэж байна.

Бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх өөрчлөлтүүдийн дунд тусгай зөвшөөрлийн сунгалтын тоог 3-аас 1 болгож хязгаарласан, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн үндсэн хэмжээг шинээр тогтоож, цаашид хэрэглээний үнийн индекстэй уялдуулан жил бүр индексжүүлэх, зэсийн зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулсан нэмэлт төлбөрийн шатлал, уурхай хаах болон нөхөн сэргээлтийн хөрөнгийг олон улсын нэр хүндтэй банк, санхүүгийн байгууллагаар баталгаажуулах эсвэл тусгай дансанд төвлөрүүлэх үүрэг зэрэг орж байна.

1.2 Конвенц соёрхон батлах тухай

129 дүгээр конвенцийг соёрхон батлуулах хуулийн төслийг 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Энэхүү конвенц батлагдсанаар Монгол Улс хөдөлмөрийн хяналтын чиглэлээр олон улсын стандартыг хүлээн зөвшөөрч, аж үйлдвэр, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн орчин, аюулгүй ажиллагаанд тавих хяналтын тогтолцоонд өөрчлөлт орох боломжтой юм.

1.3 Онцгой албан татварын тухай хуульд тамхины бүтээгдэхүүний татварыг тодотгож, нэмэлт өөрчлөлт оруулав

Засгийн газар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Одоогийн хуулиар янжуур тамхинд 100 ширхэг тутамд 5,860 төгрөг, задгай тамхинд 1 кг тутамд 4,210 төгрөгийн тогтмол хэмжээний онцгой албан татвар ногдуулж байсан бол шинэ төсөлд эдгээр тогтмол дүнгийн оронд үнийн дүнгээс хувиар тооцох татварын аргачлал руу шилжүүлэхээр тусгажээ. Тодруулбал, янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхинд 30%, дүнсэн болон задгай тамхинд 30% (үүнээс хамрын тамхинд 20%) онцгой албан татвар ногдуулахаар тогтоож, татвар тооцох аргачлалыг биет нэгж, үнийн дүнгээс хувиар тооцох аргыг хослуулсан байдлаар нарийвчлан зохицуулжээ.

1.4 Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Уг өөрчлөлтөөр Бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд хуваалт болон нөөц ашигласны татвар, шимтгэлийг өмнөх шиг талуудын харилцан тохиролцоогоор бус, харин гэрээнд заасан хувь, хэмжээгээр шууд зохицуулахаар тогтоож байна.

Энэхүү өөрчлөлт нь Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй ажиллаж буй газрын тосны компаниудын санхүүгийн тооцоог илүү урьдчилан тооцоолох боломжтой, тодорхой болгож буй ач холбогдолтой бөгөөд хуулийн төсөл одоогоор Улсын Их Хурлын байнгын хороодоор хэлэлцэгдэх шатандаа явж байна.

II. УЛСЫН ИХ ХУРАЛ: ОНЦЛОХ ТОГТООЛ

2.1 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааны зөрчлийг арилгав

Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн байна. Цэц уг дүгнэлтдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа "4 жил" гэсэн нь Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэснийг зөрчсөн болохыг тогтоосон байна.

III. ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦЛОХ ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын сүүлийн 2 долоо хоногт нийт 19 Засгийн газрын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

3.1 2026 оны Наадмын баярын амралтын өдрийг зохицуулав

Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 270 дугаар тогтоолоор Үндэсний их баяр

наадам, Ардын хувьсгалын ойн баярын 7 дугаар сарын 11, 12-ны өдрүүд Бямба, Ням гарагтай давхцаж байгаатай холбогдуулан 7 дугаар сарын 16, 17-ны өдрийг (Пүрэв, Баасан) нэмэлт амралтын өдөр болгож, 2026 он дотор багтаан нөхөн ажиллуулахыг Засгийн газрын байгууллагуудад даалгасан байна.

Засгийн газрын бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мөн адил зохицуулалт хийхийг уриалсан тул хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд ч ажлын хуваарь, харилцагчтай хийх уулзалтаа эдгээр өдрүүдэд тааруулан төлөвлөх боломжтой.

3.2 Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх журам шинээр батлагдав

Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр "Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх журам"-ыг шинээр баталсан байна. Уг журмаар мэргэжлийн нэгдсэн холбоог улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага, журмыг тодорхой болгож, бүртгэлтэй холбоотой үйлчилгээг "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-business.mn)"-ээр дамжуулан цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр заасан байна.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3
давхар, 301/a
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414